- Гаалийн тухай хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Гаалийн тухай хуульд 2022 оны 06 дугаар сарын 17, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар ГЕГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 507,993.4 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	29,464.3	24.6	(29,439.7)
Урьдчилгаа	39,727.0	0.0	(39,727.0)

Бараа материал	121,583.5	452,145.6	330,562.1
Үндсэн хөрөнгө	8,341,412.7	8,588,010.7	246,598.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,532,187.5</b>	<b>9,040,180.9</b>	<b>507,993.4</b>
Өр төлбөр	29,452.3	4,994.3	(24,458.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,502,735.2	9,035,186.6	532,451.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,532,187.5</b>	<b>9,040,180.9</b>	<b>507,993.4</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 452,145.6 мянган төгрөг болж 330,562.1 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 610,138.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ХМХ-ын албанаас 272,423.8 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан,
- ГЕГ-аас 30,951.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Шатахууны урамшуулалд 1,039.8 мянган төгрөгийн шатахууны талон хүлээн авсан,
- Акталсан үндсэн хөрөнгөөс 600.0 мянган төгрөгийн хөрөнгийг материалын орлогоор бүртгэсэн,
- ГЕГ-т 1,271.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн,
- 8,750.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан,
- Үйл ажиллагаанд 574,570.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 21,966,184.6 мянган төгрөг болж 1,484,399.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 98,813.8 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан,
- Ажилчдын 20 айлын 5 давхар орон сууцны гадна фасадын дулаалгын засварын ажлын 98,151.8 мянган төгрөгийн хөрөнгийг капиталжуулсан,
- ТӨБЗГ-ын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 90 дүгээр тогтоол, ГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/35 тоот тушаалын дагуу Сэлэнгэ аймаг дахь ХМХ-ын албаны 1,284,290.7 мянган төгрөгийн, ГЕГ-ын даргын 2022 оны А/147 дугаар тушаалын дагуу ажилчдын 20 айл, 38-н айлын орон сууцны дээврийн засварын 128,871.9 мянган төгрөг, 83,104.6 мянган төгрөгийн таблет зэрэг үндсэн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Өмнөх оны тайлангаар үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансаар бүртгэсэн 39,727.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн,
- Хөрөнгийн улсын үзлэгийн хүрээнд тус байгууллагын хяналтад авсан хөрөнгүүдийг 1,915,618.2 мянган төгрөгөөр дахин үнэлсэн,
- ГЕГ-ын даргын 2022 оны А/140 тоот тушаалын дагуу 39,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг Сайншанд дахь гаалийн газарт шилжүүлсэн,
- ТӨБЗГ-ын 2019 оны 100 дугаар тогтоол, ГЕГ-ын даргын 2021 оны А/128 тоот тушаалын дагуу Алтанбулаг боомтын 2,098,888.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан,

- ТӨБЗГ-ын 2022 оны 241 тогтоол, ГЕГ-ын даргын 2022 оны А/17 тоот тушаалын дагуу 26,290.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулж данснаас хассан гэх мэт.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,035,186.6 мянган төгрөг болж 532,451.4 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын оруулсан капитал 1,915,618.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ХМХА-аас шилжиж ирсэн 317.1 мянган төгрөгийн авлага болон акталсан хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 136,814.7 мянган төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 136,814.7 мянган төгрөгөөр бууруулсан, 1,383,483.9 мянган төгрөгөөр тайлант үеийн үр дүн буурсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,325,304.0 мянган төгрөг, нийт зарлагыг 6,325,304.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Нормативт зардлыг **80,000.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 664,022.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 95,602.7 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 671,239.5 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 98,846.0 мянган төгрөгөөр, эд хогшил,
- Урсгал засварын зардлыг 567,046.9 мянган төгрөгөөр,
- Томиллолт, зочны зардлыг 12,812.6 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 206,144.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,340.2 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 28,144.0 мянган төгрөгөөр зэрэг **2,350,198.8** мянган төгрөгөөр бууруулж, нийт **4,055,105.2** мянган төгрөгөөр баталсан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан “Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-иар хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэнтэй холбогдуулан 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг нэгтгэж 67 албан хаагч болон бараа материал, хөрөнгө шилжин ирснээр холбогдох зардлууд нэмэгдэж 2022 оны төсвийг өөрчлөн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,342,397.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 364,800.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 50,162.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 175,588.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 196,969.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 23,600.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 398,786.7 мянган төгрөгөөр/ төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,377,503.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 20,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,377,503.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 10,077.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,455,259.3 мянган төгрөг буюу 82.54 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 942,243.7 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,320,631.3	4,385,886.1	934,745.2	82.4
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	14,978.4	14,429.7	548.7	96.3
3	Харуул, хамгаалалтын зардал	55,293.3	48,343.6	6,949.7	87.4
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	6,600.0	6,600.0	0.0	100.0
	<b>Дүн</b>	<b>5,397,503.0</b>	<b>4,455,259.4</b>	<b>942,243.6</b>	<b>82.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд татаас, санхүүжилтийн авлага 29,425.3 мянган төгрөгийн орлого орж Алтанбулаг боомтын “Улаан” бүсэд баригдсан 12 түр байр, түүний теле хяналтын системийн ажлын барьцаа төлбөрийн зардалд шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тээвэр, шатахууны зарцуулалт, төрийн байгууллагын мөнгөн касстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,940,685.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 49,406.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагатай гэж дүгнэсэн.

Тайлант онд тус байгууллагад ХМХА-ыг нэгтгэснээр орон тоо, хөрөнгө, урсгал зардал нэмэгдсэн тул материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,447,844.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 64,478.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

ГЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 16-ны “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх 02 тоот албан даалгаврын хүрээнд Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь 23 арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлтийг ГЕГ-д хүргүүлсэн байна. Үүнд:

- Албан бичгийн төслийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд хэвлэж, албан хаагчидтай албаны цахим шуудангаар харьцаж бичгийн цаасны хэрэглээг бууруулсан,
- Хэвлэл захиалга хийгээгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, байгууллагын ойг тэмдэглэх зэргийг зохион байгуулаагүй,
- Зочин, төлөөлөгч хүлээн авах, үдэх, бэлэг дурсгалын зүйлсэд зардал гаргаагүй,
- Ажлын цагийн дараа компьютер, техник хэрэгслүүдийг бүрэн унтрааж хэвшсэн зэргээр нийт тогтмол зардлыг 45.5 хувиар хэмнэсэн байна.
- Сүхбаатар боомтын нэг цэгийн үйлчилгээний барилга ашиглалтад орохтой холбоотой төсөвлөсөн зардал хэмнэгдсэн гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай */бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/* нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, авлага үүсгэсэн зэрэг 39,727.0 мянган

төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн боловч 1,134.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	39,727.0	1	39,727.0	100.0
Зөвлөмж	1	1,134.0	0	0.0	0.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>40,861.0</b>	<b>1</b>	<b>39,727.0</b>	<b>97.2</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

**4.6.1** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар, Алтанбулагийн хилийн боомтуудын барилга, байгууламж баригдаж, ашиглалтад ороход бэлэн болоод байгаа бөгөөд тус барилгуудад зайлшгүй хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмжийн зардлуудыг төсвийн тухайн ангилал дээр бус бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд тусгаж өгснөөс, өөрөөр хэлбэл төсвийг зайлшгүй хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалж төсвийн эдийн засгийн ангилал хооронд **35,101.5** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**4.6.2** Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байсан Алтанбулаг боомтын барилгыг түрээслүүлэх замаар туслах үйл ажиллагаанаас 20,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. ТӨБЗГ-ын 2019 оны 100 дугаар тогтоол, ГЕГ-ын даргын 2021 оны А/128 тоот тушаалын дагуу 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Алтанбулаг боомтын барилгыг акталж, данснаас хассан боловч дээд шатны төсвийн захирагчаас орлогын төлөвлөгөөнд холбогдох зохицуулалт хийгээгүйгээс гүйцэтгэлээр 10,077.1 мянган төгрөг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг **9,922.9** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**4.6.3** Хилийн мэргэжлийн хяналтын газраас шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай 15,298.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдааг залруулахаар ГЕГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст хүсэлт хүргүүлсэн боловч тайлант хугацаанд шийдвэрлэгдээгүй байна.

Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 52,039.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 49,510.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,528.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

### **5.1 Албан шаардлага**

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажгаагүй **49,510.4** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Тээвэр, шатахууны зарцуулалттай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Олон жил ашиглагдаж байгаа хуучин авто машинуудын шатахууны зарцуулалтад ажиглалт хийж норм, нормативыг тогтоогоогүйгээс Ланд 200, Ниссан

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

урбан маркийн 2 автомашины шатахуун зарцуулалтыг жишиг нормоос **1,867.1** мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

**1.2 Өгссөн зөвлөмж:** Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-ний дагуу байгууллагын нийт автомашины шатахуун зарцуулалтын нормыг бодитоор шинэчлэн тогтоон, мөрдөж ажиллах.

## **2. Мөнгөн касстай холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:** Албан хаагчийн хувийн харилцах дансаар дамжуулан **661.5** мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дүгээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.2 дахь “*Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.2 Өгссөн зөвлөмж:** Бэлэн мөнгөөр хийгдэж буй ажил, гүйлгээг байгууллагын нярвын нэр дээрх картын дансаар дамжуулан зарцуулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан	1	49,510.4			1	49,510.4						
Шатахууны норм, нормативыг бодитоор тогтоогоогүй	1	1,867.1					1	1,867.1				
Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн	1	661.5					1	661.5				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>52,039.0</b>			<b>1</b>	<b>49,510.4</b>	<b>2</b>	<b>2,528.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								